

Сайдын үүрэг хариуцагчийн  
2022 оны ...р сарын ...ны өдрийн  
...тоот тушаалын Нэгдүгээр хавсралт

**“Алтанбулаг” чөлөөт бүсийн авто зам, талбай, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгсэл болон явган зорчигчдоос авто зам, талбай ашигласны болон хогны төлбөр авах журам”**

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Чөлөөт бүсийн авто зам, талбай, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгсэл болон явган зорчигчдоос өмчийн хэлбэр, харьяаллыг үл харгалзан авто зам, талбай, замын байгууламж ашигласны болон хогны төлбөр авахтай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Чөлөөт бүсийн авто зам, талбай, замын байгууламж ашигласны болон хогны төлбөрийн орлогыг төвлөрүүлж, төлбөр авах цэг байгуулах, засварлаж тохижуулах, төлбөр авах үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх, авто зам, талбайг сэргээн засварлах, арчилж хамгаалах, аж ахуйн ажилд зарцуулна.

**Хоёр. Төлбөр авах үйл ажиллагаанд тавигдах шаардлага**

2.1. Чөлөөт бүсэд гүний болон хилийн гарцаар 08:00-18:00 цагт нэвтэрсэн тээврийн хэрэгслийн зорчигч бүрийн тоогоор болон явган зорчигчдоос “Алтанбулаг” чөлөөт бүсийн авто зам ашигласны болон хогны төлбөрийн хэмжээнд заасны дагуу авто зам ашигласны болон хогны төлбөр авч хэрэгжүүлнэ.

2.2. Тусгай дуут болон гэрлэн дохио хэрэглэн албан үүргээ гүйцэтгэж байгаа эмнэлгийн түргэн тусламж, зэвсэгт хүчин, хил хамгаалах, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын алба, төрийн тусгай хамгаалалтын болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний зориулалттай тээврийн хэрэгсэл, төрийн албаны болон албан үүрэг гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчдын тээврийн хэрэгслийн төлбөрийг холбогдох бичиг баримтыг үндэслэн, чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн тээврийн хэрэгслийг тус тус чөлөөлнө.

2.3. Энэ журмын 2.2-т зааснаас бусад бүх тээврийн хэрэгслийн зорчигч бүрийн тоогоор болон явган зорчигчид авто зам, талбай, замын байгууламж ашигласны болон хогны төлбөр төлөх үүрэгтэй.

2.4. Төлбөр авах үйл ажиллагааг авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулахгүйгээр зохион байгуулна.

2.5. Авто зам, талбай, замын байгууламж ашигласны болон хогны төлбөрийн хэмжээг заасан тасалбарыг төлбөр төлөгчид олгоно. Тасалбарт дугаар, төлбөр авах цэгийн нэр, төлбөрийн хэмжээ, огноог тусгаж, санхүүгийн тэмдгээр баталгаажуулсан байна.

2.6. Төлбөр авах үйл ажиллагааг “Алтанбулаг” чөлөөт бүсийн гүний гарцын орох хэсэгт байгуулсан байнгын ажиллагаатай төлбөр авах цэгт /цаашид “төлбөр авах цэг” гэнэ/

төвлөрүүлэн зохион байгуулна. Төлбөр авах цэгт бүртгэлийн мэргэжилтэн байрлан ажиллана.

2.7. Төлбөр авах цэг нь шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдож, аюул осолгүй ажиллах нөхцөл боломжоор хангагдсан байна.

2.8. Төлбөр авах цэгийн орох хэсэгт тээврийн хэрэгслийн зорчигч бүр, явган зорчигчид төлбөр авсныг нотлох тасалбар олгоно.

2.9. Төлбөр авах цэг дээр тасалбаргүйгээр төлбөр хурааж авахыг хориглоно.

### **Гурав. Захирагчийн Ажлын албаны чиг үүрэг**

3.1. Захирагчийн ажлын алба нь чөлөөт бүсийн авто замын тогтоосон чиглэлд төлбөр авах цэг байгуулан үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавих, авто зам ашигласны болон хогны төлбөрийн орлогыг төвлөрүүлнэ.

3.2. Төлбөр авах цэгийн байр, ажиллагсдын аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцлийг хангаж, хууль тогтоомж, үйл ажиллагааг сурталчилсан мэдээллийн самбар байрлуулан хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллана.

3.3. Авто замыг сэргээн засварлах, зам, замын байгууламжийг барих, арчилж хамгаалах, хог хаягдлыг цэвэрлэх, устгах ажлыг сайжруулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

3.4. Төлбөр авах цэгийн орлогын тайланг тухайн сарын 30-ны өдрийн дотор гаргана.

3.5. Төлбөр авах цэг дээр тасалбар олгохгүйгээр төлбөр авсан тухайн албан хаагчид хуулийн дагуу хариуцлага тооцно.

### **Дөрөв. Авто зам ашигласны болон хогны төлбөрийн орлогын зарцуулалт**

4.1. Чөлөөт бүсийн авто зам, талбайд зорчиж буй тээврийн хэрэгсийн зорчигч бүр, явган зорчигчид тогтоосон тарифын дагуу авто зам, талбай, замын байгууламж ашигласны болон хогны төлбөрийн орлогын дараах үйл ажиллагаа, төрөл арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.

4.1.1. Төлбөр авах цэгийн байр барих түүний зам талбай, зогсоол байгуулах, тохижуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авах арга хэмжээний зардалд;

4.1.2. Чөлөөт бүсийн хогны цэвэрлэгээ, үйлчилгээнд;

4.1.3. Чөлөөт бүсийн аж ахуйн үйлчилгээнд;

4.1.4. Төлбөр авах үйл ажиллагааны талаарх хууль тогтоомж, дүрэм журмыг олон нийтэд тайлбарлан таниулах, тухайн чиглэлийн авто зам, замын байгууламжийн талаарх мэдээ, мэдээллээр зам хэрэглэгчдийг хангах зардалд;

4.1.5. Авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, авто зам, замын байгууламж барих, зам засварлах, арчлалтын ажлын зардалд;

4.2. Төлбөр авах үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, төлбөр авах цэгийн зардлыг авто зам ашигласны болон хогны төлбөрөөс тухайн сар бүрд төвлөрүүлсэн нийт орлогын дүнгээс санхүүжүүлнэ. Энэ зардалд төлбөр авах үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, ажиллагсдын цалин, урсгал зардал, хяналт шалгалт, төлбөр авах цэгийн

хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зорчигчдыг мэдээ, мэдээллээр хангах зэрэг төлбөр авах үйл ажиллагаатай холбоотой бүх зардал багтана.

### **Тав. Бусад зүйл**

5.1. Төлбөр авах цэг энэхүү журмын дагуу үйл ажиллагаа явуулна.

5.2. Төлбөр авах цэгийн хэвийн үйл ажиллагаа, ажиллагсдын аюулгүй байдлыг төлбөр авах цэгийн ажилтан, Захирагчийн ажлын алба бүрэн хариуцна.

5.3. Авто зам, талбай, замын байгууламж ашигласны болон хогны хураамжийг төлөөгүй, төлөхөөс татгалзсан иргэний тээврийн хэрэгсэл, явган зорчигчийг чөлөөт бүсэд нэвтрүүлэхгүй.

Сайдын үүрэг хариуцагчийн  
2022 оны ...р сарын ...ны өдрийн ...тоот  
тушаалын Хоёрдугаар хавсралт

“Алтанбулаг” чөлөөт бүсийн авто зам, талбай, замын байгууламж ашигласны  
болон хогны төлбөрийн хэмжээ

Тээврийн хэрэгслийн төрөл	Ангилал	Төлбөрийн хэмжээ /төгрөг/
Зорчигч, тээврийн хэрэгсэл	Бүх төрлийн суудлын автомашин, мотоцикл, унадаг дугуй	1000
Ачаа тээврийн хэрэгсэл	Бүх төрлийн ачааны автомашин	5000

Төлбөрийн тасалбарын загвар

